

Харилцагчийн зээлийн түүхийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс

Determinants of Customer Credit History Evaluation

Д. Намжил¹, Д. Отгонцэцэг², Э. Баярцэцэг³

Хураангуй

Энэхүү судалгаагаар зээлдэгчийн зээлийн түүхийн үнэлгээнд хувь хүний хандлага, санхүүгийн боловсрол, ажил эрхлэлт, зээлийн бүтэц зэрэг хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгааг “А” банкны 9,181 зээлдэгчийн 2023 оны мэдээлэлд тулгуурлан шинжилсэн. Судалгаанд тоон мэдээлэлд суурилсан харьцуулалт, задлан шинжилгээ, сэтгэл ханамжийн судалгаа зэрэг аргуудыг ашигласан. Үр дүнгээс харахад цалингийн зээл, тэр дундаа онлайн зээл нь банкны хамгийн эрсдэлтэй бүтээгдэхүүн болох нь тогтоогдсон бөгөөд барьцаа хөрөнгийн төрөл, ажил эрхлэлт, нас, хамтран үүрэг гүйцэтгэгчийн оролцоо зэрэг нь зээлийн чанарт онцгой нөлөөтэй болохыг харуулсан. Түүнчлэн ажлын байрны тогтвортой байдал, санхүүгийн хариуцлага зэргийн нөлөө илт мэдрэгдэж байгаа нь банк, хэрэглэгч, боловсролын байгууллага болон төрийн оролцоог цогцоор нь авч үзэх шаардлагатайг харуулж байна.

Түлхүүр үгс: зээлийн түүх, зээлийн чанар, цалингийн зээл, барьцаа хөрөнгө, санхүүгийн боловсрол, хамтран үүрэг гүйцэтгэгч

Abstract

This study investigates how borrowers' credit history evaluations are influenced by individual attitudes, financial literacy, employment status, and loan structure using data from 9,181 borrowers of “A” bank in 2023. Quantitative analysis, disaggregation, and satisfaction survey data were employed. The findings reveal that salary loans – particularly online loans – carry the highest risk, significantly affecting the bank's risk provisions. Key factors such as collateral type, employment sector, age group, and co-borrower participation were also shown to strongly influence loan quality. Additionally, job stability and personal financial responsibility emerged as critical determinants, highlighting the need for coordinated efforts from banks, borrowers, educational institutions, and policymakers.

Keywords: credit history, loan quality, salary loan, collateral, financial literacy, co-borrower

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, Санхүүгийн тэнхим
E-mail: namjil_9777@yahoo.com

² "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: otgontsetseg.d@erdenetis.edu.mn

³ "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль, НББ-ийн тэнхим
E-mail: bayaraae88@gmail.com

Удиртгал

Орчин үеийн банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд зээлийн чанар, зээлийн түүхийн үнэлгээ нь эрсдэлийн удирдлагын салшгүй нэг хэсэг болж байна. Зээлийн түүх нь зээлдэгчийн өнгөрсөн зээлийн авалт, эргэн төлөлтийн мэдээлэлд тулгуурлан зээлжих чадварыг тодорхойлох, ирээдүйн санхүүгийн шийдвэрт суурь болох чухал үзүүлэлт юм. Энэхүү үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлс нь зөвхөн орлого, барьцаа хөрөнгө, ажил эрхлэлт зэрэг уламжлалт шалгуураар хязгаарлагдахгүй, харин хувь хүний хандлага, санхүүгийн боловсрол, хэрэглээний зан төлөв зэрэг сэтгэлзүйн болон нийгмийн хүчин зүйлс чухал байр суурь эзэлж эхэлжээ.

Хөгжиж буй орнуудын хувьд зээлийн эрсдэл банкны ашигт ажиллагаанд хүндээр нөлөөлдөг бөгөөд зээлийн чанар муудах нь банкны активын бууралт, эрсдэлийн сангийн зардлын өсөлтөд хүргэдэг болохыг олон судалгааны үр дүн харуулсан байдаг (Jabouri & Naili, 2019). Abafita (2003) нь микрофинанс салбарын жишээн дээр хувь хүний зээлд хандах хандлага, нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд нь зээлийн эргэн төлөлтөд хэрхэн нөлөөлж буйг тогтоосон. Мөн Gebremedhin (2010) нь Этиоп улсын хөгжлийн банкны харилцагчдын мэдээлэлд тулгуурлан зээлийн хугацаа, ажил эрхлэлт, орлогын эх үүсвэр зэрэг үзүүлэлтүүдийн эерэг нөлөөг баталсан.

Монгол Улсад банкны зээлийн багц дахь эрсдэлтэй зээлийн бүтэц, түүний шалтгаан, нөлөөллийг системтэй, нарийвчилсан байдлаар тоон өгөгдөлд суурилан шинжлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Технологийн хурдацтай хөгжил,

хэрэглэгч төвтэй үйлчилгээний шинэчлэл нь зээл олголтыг хялбаршуулж байгаа хэдий ч, эрсдэлийн түвшинг нэмэгдүүлж буйг ажиглаж болно. Тухайлбал, онлайн зээл, цалингийн шуурхай бүтээгдэхүүнүүд нь богино хугацаанд өндөр эрсдэл үүсгэж буйг “А” банкны жишээн дээр тодорхой харагдаж байна. Бид энэхүү судалгаагаар дараах зорилгыг тавьсан болно:

1. зээлийн түүхийн үнэлгээнд хувь хүний хандлага, санхүүгийн боловсрол болон бусад хувьсагчдын нөлөөг тодорхойлох;
2. зээлийн бүтээгдэхүүн, барьцаа хөрөнгийн төрөл, ажил эрхлэлтийн байдал, насны бүлэг зэргийг зээлийн чанарт хэрхэн нөлөөлж байгааг тоон өгөгдөлд тулгуурлан задлан шинжлэх;
3. зээлийн чанарын бууралтад хүргэж буй гол хүчин зүйлсийг илрүүлж, бодлогын болон практик түвшинд хэрэгжүүлэх арга замыг санал болгох.

Энэхүү судалгаа нь зээлдэгчийн хандлага, сэтгэл зүйн хүчин зүйлс болон орчин үеийн санхүүгийн бүтээгдэхүүний эрсдэлийг цогцоор нь авч үзсэнээрээ онцлог бөгөөд банкны зээлийн удирдлагыг сайжруулахад бодит хувь нэмэр оруулахыг зорьсон болно.

Судлагдсан байдал

Зээлийн түүх болон зээлийн чанарт нөлөөлөх хүчин зүйлс нь олон улсад өргөн хүрээнд судлагдсан сэдвийн нэг юм. Abafita (2003) нь Этиоп улсын “Oromia Credit and Savings Share Company”-ийн жишээн дээр хийсэн судалгаандаа зээлийн эргэн төлөлтийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, хувь хүний нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон зээлийн нөхцөл нь зээлийн чанарт эергээр нөлөөлдөг болохыг харуулсан байдаг.

Jabouri & Naili (2019) нар хөгжиж буй орнуудын банкны салбарт хийгдсэн судалгаандаа зээлийн эрсдэл нь банкны санхүүгийн тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлж болзошгүйг онцолсон. Тэд зээлийн чанар муудах нь банкны активын бууралт, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг дүгнэсэн.

Gebremedhin (2010) нь Этиопын Хөгжлийн банкны зээлдэгчдийн зээлийн түүхийн үнэлгээнд хийсэн судалгаагаар зээлийн хугацаа, орлогын эх үүсвэр, ажил эрхлэлт, зээлийн бүтээгдэхүүний төрөл зэрэг нь зээл төлөлтөд эерэг нөлөөтэй болохыг тогтоосон. Гэвч хүйс, нас зэрэг хувь хүний шинж чанаруудын нөлөө бага байгааг мөн дурдсан.

Монголын нөхцөлд хийгдсэн судалгаанууд хомс боловч Саруул (2016) болон Монголбанкны тайлангууд нь зээлийн бүтэц, чанар, сангийн зардлын талаарх мэдээллийг өгдөг. Гэвч эдгээр нь зээлдэгчийн хандлага, санхүүгийн боловсрол, цахим зээлийн хэрэглээний талаарх гүнзгийрүүлсэн судалгааг төдийлөн багтаадаггүй.

Дээрх судалгаануудаас харахад зээлийн чанарт нөлөөлөх уламжлалт хүчин зүйлс (орлого, барьцаа, ажил эрхлэлт гэх мэт) чухал хэвээр байгаа боловч орчин цагийн дижитал шилжилт, онлайн зээлийн үйлчилгээ, санхүүгийн боловсрол зэрэг шинэ үзүүлэлтүүдийн нөлөөг илүү гүнзгий судлах хэрэгцээ байгааг илтгэж байна.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны зорилго нь харилцагчийн зээлийн түүхийн үнэлгээнд нөлөөлж буй хувь хүний хандлага, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс, санхүүгийн

боловсрол, зээлийн бүтэц зэрэг үзүүлэлтүүдийн нөлөөг тодорхойлох, цаашлаад банкны зээлийн эрсдэлийн сангийн зардалд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд оршино.

Судалгаанд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй "А" банкны 2023 оны 9,181 зээлдэгчийн мэдээлэлд суурилсан хувийн мэдээлэл, зээлийн ангилал, зээлийн бүтээгдэхүүний төрөл, эрсдэлийн сангийн зардал, барьцаа хөрөнгийн төрөл, зээлдэгчийн ажил эрхлэлт, нас, хүйс, зээл төлөлтийн түүх зэрэг хувьсагчдыг ашигласан.

3.1. Судалгааны дизайн

Судалгаа нь тоон шинж чанартай, тухайн банкны зээлдэгчдийн түүврийн өгөгдөлд тулгуурласан шинжилгээ хэлбэрээр хийгдсэн. Судалгаанд хэрэглэсэн үндсэн аргууд дараах байв:

- Харьцуулалтын шинжилгээ - Зээлийн бүтээгдэхүүний төрөл, барьцаа хөрөнгийн төрөл, хамтран үүрэг гүйцэтгэгчтэй эсэх, ажил эрхэлдэг салбар зэргээр ангилан бүлгүүдийн хооронд чанарын ялгааг харьцуулсан.
- Нийлмэл шинжилгээ - Түүврийн олон хувьсагчдыг харьцуулж дүн шинжилгээ хийж, давхцал болон хамаарал бүхий загваруудаар үр дүнг тайлбарласан.
- Задлан шинжилгээ - Насны бүлэг, зээлийн зориулалт, онлайн зээлийн бүтэц гэх мэтээр хэсэгчилсэн дүн шинжилгээ хийсэн.
- Сэтгэл ханамжийн судалгаа - Зээлийн хугацаа хэтэрсэн шалтгааныг тодруулах зорилгоор зээлдэгчдийн дунд авсан чанарын судалгааны үр дүнг нэгтгэж тусгасан.

3.2. Өгөгдөл ба эх сурвалж

Судалгаанд ашигласан мэдээлэл нь дараах үндсэн эх сурвалжуудаас бүрдсэн:

- “А” банкны 2023 оны зээлдэгчийн дэлгэрэнгүй өгөгдөл, чанаргүй зээлийн тайлан;
- Монголбанкны арилжааны банкуудын зээлийн төлвийн тайлан (2023);
- Зээлдэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүн;
- Судлаачийн тооцоолол, бүлэглэлт, өгөгдлийн статистик боловсруулалт.

3.3. Хэмжилтийн хувьсагчид

Судалгаанд Хүснэгт 1-т үзүүлсэн хувьсагчдыг ашигласан.

3.4. Судалгааны хязгаарлалт

Судалгааны гол хязгаарлалт нь зөвхөн нэг банкны 2023 оны мэдээлэлд суурилсан

байдал бөгөөд эдгээр үр дүнг бусад банк, олон улсын нөхцөл байдалд шууд дүгнэх боломжгүй. Мөн зарим хувьсагчид (жишээ нь: зан төлөв, санхүүгийн боловсролын түвшин) нь тоон бус хэлбэртэй тул статистик загварчлалд бүрэн оролцоогүй.

Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Судалгаанд хамрагдсан “А” банкны 9,181 зээлдэгчийн мэдээлэлд үндэслэн зээлийн түүхийн үнэлгээнд нөлөөлж буй хувьсагчдыг олон талаас шинжиллээ. Үр дүнг зээлийн бүтэц, ангилал, эрсдэлийн сангийн зардал, барьцаа хөрөнгийн төрөл, ажил эрхлэлт, насны бүлэг, хүйс, хамтран үүрэг гүйцэтгэгчийн оролцоо зэрэг үзүүлэлтээр ангилан тайлбарласан болно.

4.1 Зээлийн бүтэц ба ангилал

Нийт зээлийн багцын 33 хувийг цалингийн зээл, 29 хувийг орон сууцны зээл, үлдсэн

Хүснэгт 1. Үндсэн хувьсагчид

Хувьсагчийн төрөл	Тайлбар
Зээлийн ангилал	Хэвийн, анхаарал хандуулах, эргэлзээтэй, муу зээл
Барьцаа хөрөнгийн төрөл	Үл хөдлөх, хөдлөх хөрөнгө, ирээдүйн орлого
Зээлийн төрөл	Онлайн, уламжлалт, цалингийн, хэрэглээний зээл гэх мэт
Хүйс, нас	Хувь хүний суурь мэдээлэл
Ажил эрхлэлт	Төрийн, хувийн хэвшил, уул уурхай, боловсрол гэх мэт
Хамтран үүрэг гүйцэтгэгчтэй эсэх	Хос зээл эсвэл бие даасан зээл
Эрсдэлийн сангийн зардал	Зээлийн чанар муудахад тооцсон сангийн дүн

Хүснэгт 3. Нийт зээлийн ангилал, сая төгрөгөөр

Зээлийн ангилал	Зээлийн тоо		Зээлийн багц		Эрсдэлийн сангийн зардал	Зээлийн багцад эзлэх хувь
Хэвийн зээл	8,930	97.3%	104,389.0	97.9%	456.6	0.4%
Ангилал буурсан зээл	251	2.7%	2,241.6	2.1%	738.9	33.0%
Нийт	9,181	100%	106,630.6	100%	1,195.5	1.1%

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хүснэгт 4. Барьцаа хөрөнгийн төрөл ба эрсдэлийн сангийн зардал, сая төгрөгөөр

Зээлийн ангилал	Зээлийн тоо		Зээлийн багц		Эрсдэлийн сангийн зардал	Зээлийн багцад эзлэх хувь
Хэвийн зээл	5,855	96.6%	45,825.4	96.6%	231.6	0.5%
Ангилал буурсан зээл	206	3.4%	1,605.5	2.1%	642.4	40.0%
Нийт	6,061	100%	47,430.9	100%	874.0	1.8%

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан нийт зээлийн мэдээлэл, сая төгрөгөөр

Зээлийн бүлэг	Зээлийн багц дүн		Зээлийн ангилал				Эрсдэлийн сангийн зардал			
	Дүн	Хувь	Хугацаа	Хэвийн	Анхаарал хандуулах	Хэвийн бус	Эргэл-зээтэй	Муу	Дүн	Санд эзлэх хувь
Бизнесийн зээл	9,564.8	9%	378	256	6	-	1	2	124.5	10%
Цалингийн зээл	35,217.3	33%	30	3,201	71	26	28	65	779.4	65%
Орон сууцны зээл	35,359.3	33%	240	456	5	-	-	-	147.1	12%
Бусад хэрэглээний зээл	21,670.7	20%	60	4,821	19	6	1	11	116.4	10%
Ногоон зээл	3,511.1	3%	36	80	-	-	-	-	15.5	1%
Төсөл хөтөлбөрийн зээл	1,307.2	1%	60	117	2	5	-	1	12.7	1%
Нийт	106,630.5	100%		8,931	103	37	30	79	1,195.5	100%

Хүснэгт 5. Цалингийн зээлийг насны ангиллаар, сая төгрөгөөр

Зээлдэгчийн насны бүлэг	Зээлийн тоо		Зээлийн багцын дүн				Зээлийн ангилал, тоогоор			Эрсдэлийн сангийн зардал		Сегмент хариуцагчийн тоо	
							Хэвийн	Ангилал буурсан		Дүн	Багад эзлэх хувь		
18-25 нас	425	13%		3,320.2	9%	400	94%	25	6%	54.1	1.6%	4	1%
26-35 нас	1,309	39%		13,070.3	37%	1,217	93%	92	7%	287.5	2.2%	39	3%
36-45 нас	1,006	30%		11,646.8	33%	952	95%	54	5%	295.8	2.5%	50	5%
46-55 нас	599	18%		6,639.6	19%	585	98%	14	2%	120.8	1.8%	24	4%
56-65 нас	53	2%		540.5	2%	47	89%	6	11%	21.1	3.9%	1	2%
Нийт	3,392	100%		35,217.3	100%	3,201	94%	191	6%	779.4	2.2%	118	3%

Хүснэгт 6. Хамтран үүрэг гүйцэтгэгчтэй эсэхээр ангилсан зээлийн багц, сая төгрөгөөр

Хамтран үүрэг гүйцэтгэгчтэй эсэх	Зээлийн тоо		Зээлийн багцын дүн		Зээлийн ангилал, тоогоор			Эрсдэлийн сангийн зардал		
	Тийм		Үгүй		Хэвийн			Дүн	Нийт санд эзлэх хувь	Багад эзлэх хувь
Тийм	795	79%	211	21%	765	96%	30	4%	131.0	44%
Үгүй	1,006	100%	1,006	100%	952	95%	54	5%	295.8	100%
Нийт										2.5%

Эх сурвалж: Судлаандын тооцоолол

Хүснэгт 7. Ажил эрхэлдэг салбарын ангилал ба эрсдэлийн сан, сая төгрөгөөр

Ажил эрхэлдэг салбар	Зээлийн тоо		Зээлийн багцын дүн			Зээлийн ангилал, тоогоор			Эрсдэлийн сангийн зардал		
						Хэвийн	Ангилал буурсан	Дүн	Нийт санд эзлэх хувь	Багад эзлэх хувь	
Уул уурхай	345	34%	6,149.5	53%	325	94%	20	6%	152.9	51.7%	2.5%
Хувийн хэвшил	167	17%	1,339.4	11%	157	94%	10	6%	40.2	13.6%	3.0%
Боловсрол	149	15%	1,036.6	9%	143	96%	6	4%	29.0	9.8%	2.8%
Хууль хүчний байгууллага	107	11%	1,048.2	9%	99	93%	7	7%	37.2	12.6%	3.5%
Төрийн үйлчилгээ	52	5%	384.3	3%	51	98%	1	2%	3.3	1.1%	0.8%
Эрүүл мэндийн байгууллага	39	4%	407.6	3%	39	99%	-	1%	3.7	1.3%	0.9%
Зам тээвэр	33	3%	326.1	3%	31	94%	2	6%	5.8	2.0%	1.8%
Бусад	24	2%	209.6	2%	22	92%	2	8%	4.4	1.5%	2.1%
Банк санхүүгийн байгууллага	20	2%	256.2	2%	19	95%	1	5%	3.4	1.2%	1.3%
Шатахуун түгээгүүр	14	1%	116.5	1%	13	93%	1	7%	3.6	1.2%	3.0%
Ус, дулаан хангамж	12	1%	93.2	1%	12	100%	-	0%	0.6	0.2%	0.6%
Эрчим хүч	11	1%	69.9	1%	11	100%	-	0%	0.3	0.1%	0.4%
Барилга	9	1%	81.5	1%	6	67%	3	33%	9.9	3.4%	12.2%
Хүнд үйлдвэр	8	1%	34.9	0%	8	94%	-	6%	0.9	0.3%	2.5%
Урлаг спорт	8	1%	58.2	1%	8	94%	-	6%	0.3	0.1%	0.5%
Цахилгаан холбоо, шуудан	7	1%	34.9	0%	7	100%	-	0%	0.3	0.1%	0.8%
Нийт	1,005	1	11,646.8	100%	951	95%	53	5%	295.8	100%	2.5%

Эх сурвалж: Судлаандын тооцоолол

38 хувийг бусад төрлийн зээл эзэлж байна. Хэдий тийм боловч эрсдэлийн сангийн зардлаас 65 хувийг цалингийн зээл бүрдүүлж байгаа нь банкны хувьд хамгийн эрсдэл өндөртэй бүтээгдэхүүн болохыг харуулж байна. Хүснэгт 2-оос харахад зээлийн төрөл тус бүрийн эрсдэлийн сангийн эзлэх хувь, хугацаа, ангилал бууралт хэрхэн ялгарч буйг харж болно.

Хүснэгт 3-аас харахад нийт зээлийн 97.3 хувь нь хэвийн ангилалд байгаа боловч үлдсэн 2.7 хувь нь ангилал буурсан бөгөөд сангийн зардлын 33 хувийг дангаараа эзэлж байна. Энэ нь ангилал буурсан зээлийн нэг бүрийн эрсдэл өндөр байгааг илтгэнэ.

4.2 Барьцаа хөрөнгийн төрөл

Барьцаа хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгө болон хадгаламж дээр суурилсан барьцаат зээлийн эрсдэлийн сангийн дундаж 0.5 хувьтай байсан бол хөдлөх хөрөнгө болон ирээдүйн орлого барьцаалсан зээлийн эрсдэл 1.8 хувь байв. Хүснэгт 4-өөс энэ хандлагыг тодорхой харж болно.

4.3 Насны бүлгийн шинжилгээ

Цалингийн зээлдэгчдийн насны бүтэц, чанарын ангиллын зөрүүг Хүснэгт 5-д үзүүлсэн бөгөөд 26-35 насны зээлдэгчид зээлийн тоо болон дүнгээр тэргүүлж буй ч, 36-45 насны бүлгийн эрсдэлийн сан хамгийн их буюу 2.5 хувь байна.

4.4 Хамтран үүрэг гүйцэтгэгчийн нөлөө

Хүснэгт 6-аас харахад хамтран үүрэг гүйцэтгэгчгүй зээлийн чанар илүү сайн байгааг харуулж байна. Хамтран үүрэг гүйцэтгэгчтэй зээлийн эрсдэл нь 5.9 хувьтай байгаа нь тухайн зээлд хэт өндөр дүнгийн зээл авсан байж болзошгүйг илтгэнэ.

4.5 Ажил эрхлэлт, салбарын шинжилгээ

Зээлдэгчдийн ажил эрхэлдэг салбарын дагуу чанарын зөрүүг Хүснэгт 7-д харуулав. Барилгын салбарын зээлдэгчдийн багцын чанар хамгийн муу байгаа нь тухайн салбарын тогтворгүй байдал, улирлын ажлын онцлогтой холбоотой.

4.6 Зээлийн хугацаа хэтэрсэн шалтгаанууд

Зээлдэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгаанд суурилан Хүснэгт 8-д зээлийн хугацаа хэтэрсэн шалтгаануудыг нэгтгэн үзүүлсэн. Эндээс харахад 77.8 хувь нь ажлаас гаралттай холбоотой байна.

Хүснэгт 8. Зээлийн хугацаа хэтэрсэн шалтгаан

Зээл хугацаа хэтэрч ангилал буурсан шалтгаан	Зээлийн тоо	Хувь
Ажлаас гарч өөр ажилд орсон	23	43%
Ажлаас гарсан, өөр ажилд ороогүй	19	35%
Цалин, орлого буурсан	4	7%
Давхар зээлтэй өрийн дарамтад орсон	3	6%
Зээл авах сонирхолгүй	2	4%
Бусад	3	6%
Нийт	54	100%

Дүгнэлт

Энэхүү судалгаанд “А” банкны 2023 оны 9,181 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан зээлийн түүхийн үнэлгээнд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг тогтоон, эрсдэлийн сангийн зардалтай уялдуулан дүгнэлт гаргалаа.

Нэгдүгээрт, банкны зээлийн бүтэц, бүтээгдэхүүн үйлчилгээнээс харахад цалингийн зээл нь нийт зээлийн багцын 33 хувийг эзэлж буй томоохон багц боловч нийт эрсдэлийн сангийн зардлын 65 хувийг дангаараа бүрдүүлж байна (Хүснэгт 2-оос үзнэ үү). Ялангуяа онлайн хэлбэрээр олгогдож буй цалингийн зээл нь зээлийн

олголтыг хялбаршуулж, эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа ч зээлийн чанар буурахад голлох нөлөө үзүүлж байгааг тогтоолоо.

Хоёрдугаарт, барьцаа хөрөнгийн бүтэц зээлийн чанарт ихээхэн нөлөөтэй байна. Үл хөдлөх хөрөнгө болон хадгаламжид суурилсан зээлийн багцын эрсдэл 0.5 хувьтай байхад хөдлөх хөрөнгө, ирээдүйн орлого барьцаалсан зээлд энэ үзүүлэлт 1.8 хувьтай байна. Энэ нь барьцааны төрөл нь зээлдэгчийн хариуцлагатай байдал, төлөх сонирхолд нөлөөлж байгааг харуулж байна (Хүснэгт 4).

Гуравдугаарт, зээлдэгчийн нас болон ажил эрхлэлт зээлийн чанарт шууд нөлөөлж байна. 36-45 насны бүлгийн зээлдэгчид нийт зээлийн 30 хувийг бүрдүүлж байгаа ч энэ бүлэгт харьяалагдах зээлдэгчдийн эрсдэлийн сангийн дундаж 2.5 хувьтай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна (Хүснэгт 5).

Дөрөвдүгээрт, хамтран үүрэг гүйцэтгэгчтэй зээлүүдийн эрсдэл илүү их буюу 5.9 хувь байгаа нь зээлдэгчийн хариуцлага, төлөвлөлт сул байж болзошгүйг илтгэж байна. Энэ нь зөвхөн нэмэлт орлого баталгаажуулах зорилготой зээл судлуулалт урт хугацаанд зээлийн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүйг харуулж байна (Хүснэгт 6).

Тавдугаарт, ажил эрхэлдэг салбарын тогтвортой байдал зээлийн чанарт ихээхэн нөлөөтэй байна. Барилгын салбарт ажиллагчдын зээлийн багцын 12.2 хувь нь ангилал буурсан бөгөөд энэ нь судалгаанд хамрагдсан бүх салбар дундаа хамгийн их эрсдэлтэй нь байв. Харин төрийн үйлчилгээ, эрүүл мэндийн салбарын зээлдэгчид хамгийн бага эрсдэлтэй зээлийн багцыг бүрдүүлж байна (Хүснэгт 7).

Зургаадугаарт, зээл хугацаа хэтэрсэн гол шалтгаанууд нь ажлаас гаралт, орлого тасалдалтай холбоотой байв. Хүснэгт 8-аас харахад ангилал буурсан зээлийн 77.8 хувь нь ажлын байрны өөрчлөлт, тогтворгүй байдалтай шууд холбоотой байсан нь ажил эрхлэлт болон орлогын тогтвортой байдал зээлийн чанарт шууд нөлөөлж байгааг нотолж байна.

Долоодугаарт, зээлдэгчийн хүйсийн хувьд эмэгтэйчүүд илүү хариуцлагатай байж, эрсдэлийн түвшин харьцангуй бага байв.

Эдгээр үр дүнг үндэслэн дараагийн хэсэгт зээлийн чанарыг сайжруулах, сангийн зардлыг бууруулах зорилго бүхий бодлогын болон практик санал, арга замыг дэвшүүлж байна.

Санал, хэрэгжүүлэх арга зам

Судалгааны үр дүнгээс харахад зээлийн чанарын доройтол, банкны эрсдэлийн сангийн өсөлт нь зөвхөн уламжлалт хүчин зүйл (барьцаа, орлого, ажил эрхлэлт) төдийгүй харилцагчийн хандлага, санхүүгийн боловсрол, онлайн зээлийн хэрэглээтэй шууд холбоотой байна. Иймд дараах түвшний оролцогч талуудад зориулан санал, арга хэмжээг дэвшүүлж байна:

Банк, санхүүгийн байгууллагад:

- Санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх: Зээл олгохын өмнө харилцагчдад зориулсан богино хэмжээний санхүүгийн зөвлөгөө, танилцуулга мэдээлэл өгөх сургалт, контент системтэй хэрэгжүүлэх. Цахим суваг, мобайл аппликейшн ашиглан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Онлайн зээлийн хэрэглээтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг сайжруулах: Онлайн зээлийн бүтээгдэхүүнийг зөвхөн хурдан олголт дээр төвлөрөхөөс

илүүтэй, зээлийн зориулалт, төлбөрийн чадварыг үнэлэх нэмэлт шалгуур (eKYC, AI-суурилсан credit scoring) нэвтрүүлэх.

- Хамтран үүрэг гүйцэтгэгчийн бодлогыг хянаж үзэх: Зээлийн нөхцлийг нэмэлт орлогоор баталгаажуулсан ч, хариуцлагын түвшин сул байгаа харилцагчдад хязгаарлалттай нөхцөл тогтоох.
- Зээлийн мэдээлэлд тулгуурлан зорилтот санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх: Эрсдэл ихтэй бүлгүүдэд тусгай нөхцөл, хяналттай бүтээгдэхүүн (жишээ нь, жижиг хэмжээтэй хяналттай хэрэглээний зээл) санал болгох.
- Зээлийн чанарт нөлөөлөх өгөгдөлд суурилсан эрт сэрэмжлүүлэх систем нэвтрүүлэх: Зээлийн хугацаа хэтрэх магадлалтай зээлдэгчдийг урьдчилан илрүүлж, холбоо барих, дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийж хэрэгжүүлэх.

Зээлдэгч, харилцагчийн түвшинд:

- Санхүүгийн хариуцлагатай байдалд суралцах: Зээлийн хэрэглээнд ухаалаг, төлөвлөлттэй хандаж, зөвхөн яаралтай, зайлшгүй хэрэгцээнд зориулж зээл авах; төлбөрийн хуваарийг урьдчилан тооцож, нөөц төсөв гаргах.
- Хувийн санхүүгийн боловсролоо дээшлүүлэх: Өрхийн орлого, зарлагаа хянах дадалтай болох, зээлийн эрсдэл, хүү, шимтгэл зэрэг нөхцөлүүдийг харьцуулж ойлгодог чадвар эзэмших.
- Өрхийн хэмжээнд санхүүгийн боловсрол олгох соёлыг бий болгох: Гэр бүлийн хүрээнд хүүхэд, өсвөр насныханд хэрэглээ, зээлийн талаарх ойлголтыг зөв суулгах.

Боловсролын байгууллагад:

- Санхүүгийн боловсролыг боловсролын шат дамжлагад тусгах: Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн хөтөлбөрт санхүүгийн боловсролын үндэсний стандартын дагуу мэдлэг, чадварыг системтэй олгох. Сургуулийн өмнөх боловсролоос эхлэн хэрэгцээ, хэрэглээний ялгаа, мөнгөний үнэ цэнийн талаарх суурь ойлголт олгох.

Хөдөлмөр эрхлэлт, аж ахуйн нэгжийн түвшинд:

- Тогтворгүй салбаруудад ажиллагсдын санхүүгийн дэмжлэг, сургалтыг өргөжүүлэх: Барилга, хувийн хэвшлийн салбарт ажиллагсдын зээл төлөх чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүгийн зөвлөмж, хуримтлалын хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Ажил олгогчийн зүгээс урамшууллын хэлбэрийг шинэчлэх: Ажилтнуудын урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодит дэмжлэг (жишээ нь, хуримтлал үүсгэхэд хувь нэмэр оруулах, боловсролын сангаас тэтгэлэг олгох зэрэг) үзүүлэх.

Төр, зохицуулагч байгууллагын түвшинд:

- Санхүүгийн боловсролын бодлогыг төрийн түвшинд хэрэгжүүлэх: Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк болон Боловсролын яам хамтран зорилтот бүлэгт чиглэсэн олон нийтийн санхүүгийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Банк, санхүүгийн салбарын эрсдэлийн ангиллыг шинэ нөхцөл байдалд тохируулан шинэчлэх: Дижитал бүтээгдэхүүний онцлогт тохирсон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулах.

Ашигласан материал

- Abafita, J. (2003). *Microfinance and loan repayment performance: A case study of the Oromia Credit and Savings Share Company (OCSSCO) in Kuyu* (Master's thesis, Addis Ababa University). Retrieved from <https://etd.aau.edu.et/items/e48a9066-50f8-489e-88ce-c93fdbcdb428>
- Gebremedhin, K. T. (2010). *Determinants of successful loan repayment performance of private borrowers in Development Bank of Ethiopia, North Region* (Master's thesis, Mekelle University). Retrieved from <https://core.ac.uk/download/pdf/29135996.pdf>
- Jabbouri, I., & Naili, M. (2019). Determinants of nonperforming loans in emerging markets: Evidence from the MENA region. *Review of Pacific Basin Financial Markets and Policies*, 22(4), 1950026. <https://doi.org/10.1142/S0219091519500267>
- Саруул, Х. (2016). Банкны зээлийн судалгаа. Монголбанкны дотоод судалгааны тайлан
- Монголбанк (2023). Арилжааны банкнуудын зээлийн төлвийн тайлан. Улаанбаатар: Монголбанк
- "А" банк (2023a). Зээлийн дэлгэрэнгүй тайлан ба чанаргүй зээлийн мэдээлэл
- "А" банк (2023b). Зээлдэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн